




ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ





АЛБАНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

ЦЕГ-ын 2021.01.13-ны
өдрийн А/14 тоот тушаал



Одоо тус алба 4 газар, 15 хэлтэс, 12 тасагтай, албаны бүтцийн нэгжийн 661, нийслэлийн дүүрэг, орон нутаг дахь Замын цагдаагийн нэгжид 646, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг дэх замын цагдаагийн нэгжид 19, нийт 1326 алба хаагчтай, энгийн 27 ажилтантай улсын хэмжээнд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.



АЛБАНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ



Тээврийн цагдаагийн алба нь Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:

- **Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,**
- **Төмөр зам,**


- **Нисэх онгоцны буудлын нутаг дэвсгэр, аюултай бүс, зурвас газарт мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, осол, хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.**



ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР



Хууль, тогтоомж, цагдаагийн байгууллагын зорилго, зорилт, хөгжлийн хөтөлбөрт албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, ойрын болон хэтийн зорилт, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх, албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэднийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, бие бялдар, сэтгэлзүйн бэлтгэл олгох, гэмт хэрэг, осол, зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хариуцсан чиглэлийн хүрээнд тухай бүр гаргуулан авч ашиглах, удирдлагыг мэдээллээр хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн төрөл мэргэжлийн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.





МӨРДӨН ШАЛГАХ ГАЗАР



Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, шийдвэрлэх, эзэн холбогчийг олж тогтоох үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, албаны бүтцийн нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, улсын хэмжээнд үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийг хөтлөх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах ажлыг хариуцан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.





ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР



Төмөр замын аюултай бүс, төмөр замын өртөө, зөрлөг, зангилаа, зурвас газар, салбар нэгж, байгууллага болон ачаа тээш, зорчигчийн галт тэргэнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорчигчдын амгалан тайван байдлыг хангах, авто замын хөдөлгөөнийг зохицуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.






ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС



Иргэний нисэхийн хориотой, хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсэд мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, уг бүсэд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, Иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, тэдэнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.





ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР



Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хуулийн 8 дугаар зүйлд заасан цагдаагийн байгууллагын эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, харьяа нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрийн гаргасан судалгаа, шинэ санал, санаачлагад үндэслэн хуулиар үүрэг хүлээсэн холбогдох ажил, арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.






ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Замын хөдөлгөөний хяналтын хэлтэс

Нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, төрийн өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн айлчлал болон олон нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, гудамж замын хөдөлгөөн зохицуулалт, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Дэлхий нийтэд тархсан коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, Монгол Улсын иргэдийг халдвараас хамгаалах зорилгоор Засгийн газар, Улсын болон Нийслэлийн Онцгой комиссоос гаргаж буй тогтоол, захирамж, тушаал, шийдвэрийн хүрээнд хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хуваарийг боловсруулан удирдлагад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.






ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтэс /гэрээт/

Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтэс /гэрээт/-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны “Тээврийн цагдаагийн албаны бүтэц, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/14 дүгээр тушаалын дагуу тус хэлтсийг дарга 1, ахлах зохицуулагч 6, зохицуулагч 54, цагдаа зохицуулагч 81, нийт 142 алба хаагчийн орон тоотойгоор байгуулсан.

Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр нийслэлийн 6 дүүргийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж 74 уулзвар замд хөдөлгөөний зохицуулалт, хяналт шалгалт хийж 44 уулзварыг телекамерын тусламжтай гэрлэн дохиогоор хөдөлгөөнийг зохицуулж шаардлагатай үед алба хаагчдаар биет зохицуулалт хийлгэж замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

Тус хэлтсийн алба хаагчдын цалин хөлс, ажиллах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалтыг Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолыг үндэслэн шийдвэрлэж байсныг Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор хүчингүй болгосноор дээрх 160 алба хаагчийн цалин урамшууллын эх үүсвэр, чиг үүргийн зохицуулалт тодорхой бус болсныг холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх шаардлагатай байгаа болно.





ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс /гэрээт/

Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь анх НИТХ-ын 2010 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 31 дүгээр тогтоол, Нийслэлийн засаг даргын 2010 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 292 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтарч ажиллах чиг үүрэгтэй, хөдөлгөөн зохицуулах 1, 2 дугаар тасагтай, нийт 120 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд 2016 онд 40 алба хаагчийн орон тоо нэмэгдэж, үйл ажиллагаагаа өргөтгөн ажиллаж ирсэн.

Одоо тус хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/13 дугаар тушаалаар тус албаны Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс /гэрээт/ нэршилтэйгээр Нийслэл хотын замын хөдөлгөөний гэрлэн дохионы зохицуулалт, теле камерын хяналт хариуцан ажиллах чиг үүрэгтэй, хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, ахлах зохицуулагч 2, зохицуулагч 13, бичиг хэрэг 1, нийт 18 алба хаагчийн орон тоотой үүрэг гүйцэтгэж байна.






ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Зам тээврийн хяналт, зохицуулалтын хэлтэс

Зам, тээврийн хяналт зохицуулалтын хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/13 дугаар тушаалаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 2, ахлах зохицуулагч 2, зохицуулагч 2, зураглаач-оператор 1, нийт 8 алба хаагчийн орон тоотой байгуулагдсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, тээврийн хэрэгсэл, авто зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэлд тавих хяналтын ажлыг улсын хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлэх, энэ чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.





ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Орон нутгийн замын хяналтын хэлтэс

Орон нутгийн замын хяналтын хэлтэс нь дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, ахлах зохицуулагч 2, зохицуулагч 7, тасгийн дарга 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 5, нийт 18 алба хаагчийн орон тоотой үүрэг гүйцэтгэж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг орон нутаг, тууш замын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, аймгууд дахь замын цагдаагийн нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.






ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Хамгаалалтын хэлтэс

Хамгаалалтын хэлтэс нь дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, хамгаалалтын төлөвлөлт хариуцсан ахлах зохицуулагч 1, ахлах зохицуулагч 4, зохицуулагч 6, цагдаа зохицуулагч 27, нийт 40 алба хаагчийн орон тоотой үүрэг гүйцэтгэж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын болон төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, замын хөдөлгөөнд хяналт тавих, хамгаалуулагчийн зорчин явах үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдах, хяналт тавих, төлөвлөх, эрсдлийг тооцох, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийн хамгаалалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.





ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Зам, тээврийн гэрээт цагдаагийн хэлтэс

Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 11 дүгээр хуралдаанаар “Улаанбаатар-Дархан” чиглэлийн замд авто замын барилгын ажлын гүйцэтгэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт тавих үүрэг бүхий цагдаагийн гэрээт нэгжийг ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар Зам, тээврийн гэрээт цагдаагийн хэлтсийг 38 алба хаагчийн орон тоотой байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газар болон “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГазрын 2020 онд хамтран ажиллах ХАГ20/01-20/01 гэрээний дагуу 30 алба хаагчийн орон тоотой шинэчлэн батлагдаж, өнөөдрийн байдлаар 16 алба хаагчтай үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Дээрх гэрээ нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон бөгөөд Засгийн газрын энэ оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 4 дүгээр хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн сайд гэрээт цагдаагийн хэлтсийг үргэлжүүлэн ажиллуулах талаар санал танилцуулснаар тус хуралдааны тэмдэглэлээр гэрээт цагдаагийн нэгжийг 2021 онд үргэлжүүлэн ажиллуулах чиглэлээр арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасны дагуу тус хэлтсийн 2021 оны гэрээт төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, ЗТХЯамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

